



Засгийн газрын Хэрэг эрхлэх газар

**Монгол Улсын Нээлттэй Засгийн
Түшнлэлийн 2014-2016 оны
“Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө-I”**

Өөрийн үнэлгээний эцсийн тайлан
Монгол Улс
2016 он

Үйл ажиллагааны гүйцэтгэлийн загвар хүснэгт				
3.3.1.1.Төрийн мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх				
Хариуцан хэрэгжүүлэгч байгууллага		Хууль зүйн яам		
Хэрэгжүүлэгч байгууллагаас хариуцсан хүний нэр				
Газар, хэлтсийн нэр		Төрийн захиргаа, удирдлагын газрын мэргэжилтэн		
И-мейл хаяг				
Утас				
Бусад оролцогч талууд	Засгийн газар	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам		
	ИНБ-ууд, хувийн салбар, ажлын хэсгүүд, болон олон талт оролцоо	-		
Гол зорилт		Төрийн мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрх”-ийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, хяналт тавих ажлыг эрчимжүүлнэ.		
Үйл ажиллагааны товч тодорхойлолт (140 тэмдэгтийн хязгаартай)		Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулж, Мэдээллийн ил тод байдлын Үндэсний зөвлөл байгуулж, мэдээллийн комиссарын бүтцийг бий болгох.		
Хамаарал: Уг үйл ажиллагаа нь НЗТ-ийн зарчмууд болох мэдээллийн нээлттэй байдал, төрийн хариуцлага, иргэний оролцоо, технологийн дэвшил зэргийг хэрхэн хангаж буй талаар товчхон тодорхойлох.		НЗТ-ийн зарчим нь мэдээллийн ил тод байдал болон мэдээлэл авах нээлттэй байдлыг нэмэгдүүлэх өндөр ач холбогдолтой. Мөн Засгийн газрыг үйл ажиллагааныхаа хэрэгжилт, санхүүгийн болон хуулийн талаарх мэдээлэлдээ хариуцлагатай байлгах талаараа хамааралтай байна.		
Уг үйл ажиллагааны зорилтод үр дүн: Засгийн газрыг хэрхэн илүү нээлттэй болгож, Засгийн газрын үйл ажиллагааг сайжруулж буй талаар товчхон тодорхойлох.		Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулж, Мэдээллийн ил тод байдлын Үндэсний зөвлөл байгуулж, мэдээллийн комиссарын бүтцийг бий болгосноор Засгийн газраас иргэдийг мэдээллээр хангах нээлттэй байдлыг илүү бэхжүүлнэ.		
Гүйцэтгэлийн түвшин	Эхлээгүй	Хязгаарлагдмал	Биелэгдэх дөхөж байгаа	Биелэгдсэн
			х	

Үр дүнгийн тодорхойлолт: Тайлангийн хугацаан дахь онцлох үйл ажиллагаануудын үр дүн	Монгол Улсын Их Хурал 2009 оны 6 дугаар сард “Мэдээллийн ил тод байдал болон Мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийг баталсан. Уг хуулинд санхүү, төсөв, хүний нөөц болон худалдан авах ажиллагааны ил тод байдлыг мэдээлж үүнд Авилгалтай тэмцэх газар болон төрийн бус байгууллагууд байнгын хяналт тавин ажиллаж байна. 2014 оны 7 дугаар сард энэхүү хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж, 9 дүгээр зүйл (Төсөв, санхүүгийн ил тод байдал) болон 10 дугаар зүйлийг (Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал) тус тус хассан. Эдгээр хасагдсан зүйлүүд “Шилэн дансны тухай хууль”-ийн нэг хэсэг болов. Хууль зүйн яамны бодлого, үйл ажиллагааны талаар иргэдэд мэдээлэл өгөх, асуудал хариуцсан ажилтантай нь шуурхай холбож өгөх, сонин, телевизтэй байгуулсан гэрээний дагуу сэдэв, хугацаа, хуваарь батлах, зохион байгуулах, олон нийтэд мэдээлэх, яамны үйл ажиллагаа, цаг үеийн үйл явдлыг тухай бүр мэдээлэх, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд ХЗЯ-наас боловсруулан УИХ-д өргөн мэдүүлсэн болон боловсруулж байгаа хуулиудын талаар тусгайлсан хөтөлбөрийн дагуу сурталчилгаа явуулах, яамны цахим хуудасны мэдээллийг байнга шинэчлэх зэрэг ажлуудыг хийсэн. Мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр харьяа агентлаг, байгууллагууд цахим хуудсаа шинэчилж, цахим хуудсаар олон нийтэд мэдээлэл түгээж байна. Мөн харьяа агентлаг, байгууллагын мэдээллийн стратеги батлуулж, хэрэгжүүлэх чиглэлээр Хууль зүйн яам хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах стратегийг боловсруулсан.
Дуусах өдөр	2016
Дараагийн алхмууд	-
Нэмэлт мэдээлэл (Уг үүрэг амлалтыг гүйцэлтдүүлэхэд ямар ажил үлдсэн талаар болон түүнийг хэрэгжүүлэхэд тулгарч буй ямар нэгэн бэрхшээл, эрсдэл байгаа эсэхийг тодорхойлох)	
-	

Үйл ажиллагааны гүйцэтгэлийн загвар хүснэгт				
3.3.1.2.Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийг “иргэн төвтэй” болгож шинэчлэх				
Хариуцан хэрэгжүүлэгч байгууллага		Засгийн газрын Хэрэг эрхлэх газар		
Хэрэгжүүлэгч байгууллагаас хариуцсан хүний нэр		Х.Оюунцэцэг		
Газар, хэлтсийн нэр		Хяналт, үнэлгээ, шалгалт, дотоод аудитын газрын дарга		
Имейл хаяг		Oyuntsetseg_kh@cabinet.gov.mn		
Утас		260358		
Бусад оролцогч талууд	Засгийн газар	-		
	ИНБ-ууд, хувийн салбар, ажлын хэсгүүд, болон олон талт оролцоо	Иргэний нийгмийн байгууллагууд		
Гол зорилт		Төрийн мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрх”- ийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, хяналт тавих ажлыг эрчимжүүлэх		
Үйл ажиллагааны товч тодорхойлолт (140 тэмтэгтийн хязгаартай)		Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийг “иргэн төвтэй” болгож шинэчлэх		
Хамаарал: Уг үйл ажиллагаа нь НЗТ-ийн зарчмууд болох мэдээллийн нээлттэй байдал, төрийн хариуцлага, иргэний оролцоо, технологийг дэвшил зэргийг хэрхэн хангаж буй талаар товчхон тодорхойлох.		НЗТ-ийн зарчмын мэдээллийн ил тод байдал болон мэдээлэл авах нээлттэй байдлыг нэмэгдүүлэх өндөр ач холбогдолтой.		
Уг үйл ажиллагааны зорилтод үр дүн: Засгийн газрыг хэрхэн илүү нээлттэй болгож, Засгийн газрын үйл ажиллагааг сайжруулж буй талаар товчхон тодорхойлох.		Уг үйл ажиллагааны зорилтод үр дүн нь Засгийн газрыг үйл ажиллагааныхаа хэрэгжилт, санхүүгийн болон хуулийн талаарх мэдээлэлдээ хариуцлагатай байлгаж, иргэдэд илүү нээлттэй болгох.		
Гүйцэтгэлийн түвшин		Эхлээгүй	Хязгаарлагдмал	Биелэгдэх дөхөж байгаа
				х
				Биелэгдсэн

Үр дүнгийн тодорхойлолт: Тайлангийн хугацаан дахь онцлох үйл ажиллагаануудын үр дүн	Засгийн Газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний журам”-аар төрийн бүх шатны байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгийн байгууллагаар хэрэглэгчийн үнэлгээ хийлгэж байгууллагын үйл ажиллагааг үнэлдэг гол шалгуур үзүүлэлт болгон ашиглаж хэвшсэн. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2014 оны “Шалгуур үзүүлэлт батлах тухай” 88 дугаар тушаалаар яам, аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааг үнэлэхдээ Засаглалын болон эдийн засаг, нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийг ашиглаж хэвшлээ. Уг шалгуур үзүүлэлтэд иргэд, олон нийтийн оролцоотой буюу төсвийн төсөлд иргэдийн өгсөн саналыг тусгасан шийдвэрийн эзлэх түвшин, иргэд, ААН болон харилцагч бусад байгууллагаас гаргасан нийт хүсэлт, гомдлыг хуулийн хугацаанд бодитой шийдвэрлэсэн асуудлын түвшин гэх мэт олон үзүүлэлтүүдийг багтаасан нь төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдал, төрийн байгууллагын үйл ажиллагааг үнэлэхдээ иргэн төвтэй шалгуур үзүүлэлтүүд ашиглаж хэвшсэнийг тодотгож байна. Мөн Авлигатай тэмцэх газар нь Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээллэж байна. Уг үнэлгээний дүнг захиргааны байгууллагын үйл ажиллагааны үнэлгээнд үзүүлэлт болгон ашиглаж байна.
Дуусах өдөр	2015
Дараагийн алхмууд	-
Нэмэлт мэдээлэл (уг үүрэг амлалтыг гүйцэлтдүүлэхэд ямар ажил үлдсэн талаар болон түүнийг хэрэгжүүлэхэд тулгарч буй ямар нэгэн бэрхшээл, эрсдэл байгаа эсэхийг тодорхойлох)	
-	

Үйл ажиллагааны гүйцэтгэлийн загвар хүснэгт				
3.3.1.3.Төсвийн ил тод байдлыг хангах				
Хариуцан хэрэгжүүлэгч байгууллага		Сангийн яам		
Хэрэгжүүлэгч байгууллагаас хариуцсан хүний нэр		Б.Мөнх-Эрдэнэ		
Газар, хэлтсийн нэр		Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн		
Имейл хаяг		munkherdene_b@mof.gov.mn		
Утас		+97651264522		
Бусад оролцогч талууд	Засгийн Газар	Худалдан авах ажиллагааны газар		
	ИНБ-ууд хувийн салбар, ажлын хэсгүүд, болон олон талт оролцоо	-		
Гол зорилт		Төсвийн ил тод байдлыг хангах “Шилэн данс”, “Шилэн тендер”-ийн тогтолцоонд шилжинэ.		
Үйл ажиллагааны товч тодорхойлолт (140 тэмтэгтийн хязгаартай)		Төсвийн бүрдүүлэлт, орлого, зарлагын задаргаа, хөрөнгө оруулалт, төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилт, үр дүнг олон нийтэд ил тод, тогтмол мэдээлэх		
Хамаарал: Уг үйл ажиллагаа нь НЗТ-ийн зарчмууд болох мэдээллийн нээлттэй байдал, төрийн хариуцлага, иргэний оролцоо, технологийг дэвшил зэргийг хэрхэн хангаж буй талаар товчхон тодорхойлох.		Мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлэх ач холбогдол бүхий хамааралтай.		
Уг үйл ажиллагааны зорилтод үр дүн: Засгийн газрыг хэрхэн илүү нээлттэй болгож, Засгийн газрын үйл ажиллагааг сайжруулж буй талаар товчхон тодорхойлох.		Төсвийн ил тод байдлыг хангаж Засгийн газрыг илүү нээлттэй болгож байна.		
Гүйцэтгэлийн түвшин	Эхлээгүй	Хязгаар лагдмал	Биелэгдэх дөхөж байгаа	Биелэгдсэн
				х

Үр дүнгийн тодорхойлолт: Тайлангийн хугацаан дахь онцлох үйл ажиллагаануудын үр дүн.	- Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоолоор “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ыг боловсруулан батлуулсан. - Шилэн дансны тухай хууль, холбогдон гарсан журмыг олон нийтэд таниулан сурталчилах, мэдээлэл арга зүйгээр ханган ажиллах хүрээнд яам, агентлаг, аймаг, нийслэл, дүүрэг зэрэг төв болон орон нутгийн төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит компани, төрийн бус байгууллагын нийт 15,000 орчим албан хаагчдад 112 удаагийн сургалтыг зохион байгуулсан. - “Шилэн дансны тухай хууль, Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын эмхтгэлийг 25000 ширхэгийг хэвлүүлэн төсөвт байгууллагуудад хүргүүлж ажилласан. - Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 10-ны дотор http://www.mof.gov.mn вэб сайтын төсвийн гүйцэтгэл хэсэгт тогтмол байршуулан ил тод мэдээллэн ажиллаж байна. - Тендерт шалгарсан болон шалгараагүй компаниудын тендерийн материалыг ил тод цахим хуудсанд байршуулснаар олон нийтээс гардаг хандлага, буруу, ташаа мэдээллийг эрс багасгасан. - Хөрөнгө оруулалт, төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилт, үр дүнг нэгтгэн https://tender.gov.mn цахим хуудсыг ажиллуулж байна. Энэхүү цахим хуудсандаа 2016 оны байдлаар 2965 тендерийн урилгыг нийтэлснээс 567 тендерийн үр дүн оруулсан байгаа нь захиалагч байгууллагууд тендерийн үр дүнг олон нийтэд мэдээллэхэд хангалтгүй ажилласан байна. Иймд захиалагч байгууллагууд болох төрийн байгууллагууд нь цахим хуудсанд худалдан авах ажиллагааны гэрээтэй холбоотой мэдээллээ нийтлэх ажлыг сайжруулах чиглэлээр тасралтгүй холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.
Дуусах өдөр	2016
Дараагийн алхмууд	-

Нэмэлт мэдээлэл (уг үүрэг амлалтыг гүйцэлтдүүлэхэд ямар ажил үлдсэн талаар болон түүнийг хэрэгжүүлэхэд тулгарч буй ямар нэгэн бэрхшээл, эрсдэл байгаа эсэхийг тодорхойлох)
-

Үйл ажиллагааны гүйцэтгэлийн загвар хүснэгт		
3.3.1.4. Ашигт малтмал, газрын тос, болон тусгай зөвшөөрлийн ил тод байдал		
Хариуцан хэрэгжүүлэгч байгууллага	Ашигт малтмалын газар, Олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах төслийн ажлын алба	
Хэрэгжүүлэгч байгууллагаас хариуцсан хүний нэр	Н.Чинбаатар, Ш.Цолмон	
Газар, хэлтсийн нэр	Кадастрын хэлтсийн дарга, Ажлын албаны зохицуулагч	
Имэйл хаяг	Chinbaa_8763@yahoo.com	
Утас	263640	
Бусад оролцогч талууд	Засгийн газар	Үндэсний дата төв
	ИНБ-ууд хувийн салбар, ажлын хэсгүүд, болон олон талт оролцоо	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Үндэсний зөвлөл, Ажлын хэсэг
Гол зорилт	Ашигт малтмал, газрын тосны болон газар эзэмших тусгай зөвшөөрлийг ил тод болгож, иргэдийн хяналтанд оруулах	
Үйл ажиллагааны товч тодорхойлолт (140 тэмтэгтийн хязгаартай)	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж “цахим газрын зураглал”-аар үзүүлэх. Үүнд: Тусгай зөвшөөрөл эзэмшигч хувь хүн, эзэмшигч хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, тусгай зөвшөөрлийн эхлэх, дуусах хугацаа, орд, газрын байршил, хамрах хэмжээ, нөхөн сэргээлтийн талаарх мэдээллийг байршуулж, иргэдийн хяналтад оруулах.	
Хамаарал: Уг үйл ажиллагаа нь НЗТ-ийн зарчмууд болох мэдээллийн нээлттэй байдал, төрийн хариуцлага, иргэний оролцоо, технологийг дэвшил зэргийг хэрхэн хангаж буй талаар товчхон тодорхойлох.	Мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлэх ач холбогдол бүхий хамааралтай.	

Уг үйл ажиллагааны зорилтод үр дүн: Засгийн газрыг хэрхэн илүү нээлттэй болгож, Засгийн газрын үйл ажиллагааг сайжруулж буй талаар товчхон тодорхойлох.	Ашигт малтмал, газрын тосны болон газар эзэмших тусгай зөвшөөрлийг ил тод болгож, иргэдийн хяналтад оруулснаар Засгийн газраа сайжруулах			
Гүйцэтгэлийн түвшин	Эхлээгүй	Хязгаарлагдмал	Биелэгдэх дөхөж байгаа	Биелэгдсэн
			х	
Үр дүнгийн тодорхойлолт: Тайлангийн хугацаан дахь онцлох үйл ажиллагаануудын үр дүн	Дэлхийн банкны “Засаглалыг дэмжих төсөл”-ийн хүрээнд “Уул уурхайн кадастрын компьютержсэн систем” /УУККС/ төсөл АМГ-т хэрэгжиж дууссан. Төсөл хэрэгжсэнээр автоматжуулсан бүртгэл, кадастрын системийг бий болгон тусгай зөвшөөрлийн эрх олгох түүнтэй холбогдсон үйл ажиллагааны менежментийг илүү боловсронгуй, түргэн шуурхай болгож http://cmcs.mram.gov.mn/CMCS/#cid=1 цахим хуудсаар ил тод мэдээллэж байна. Мөн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын хүрээнд Европын сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр ОУИТБС-ын цахим тайлагналын системийг / http://tailan.eitimongolia.mn / бий болгосон. АМГТГ-ын кадастрын системээс тусгай зөвшөөрлийн мэдээллийг авч тус системд оруулан ОУИТБС-ын стандартаар шаардсан мэдээллүүдийг ил тод болгож байна. Үүнд: Тусгай зөвшөөрлийн дугаар, талбайн нэр, талбайн хэмжээ, ашигт малтмалын төрөл, эзэмшигч аж ахуйн нэгж, олгосон огноо, дуусах огноо зэрэг болно. Тусгай зөвшөөрлийн мэдээллүүдийг иргэдэд хүртээмжтэй хэлбэрээр газрын зурагт байршуулан үзүүлдэг бөгөөд хэрэглэгчид тусгай зөвшөөрлийн оршин буй аймаг сум, дугаар, талбайн нэр, эзэмшигч компани, ашигт малтмалын төрөл гэх мэт мэдээллээр шүүлт хийж нээлттэй өгөгдлийн форматын дагуу хүснэгтэн мэдээлэл хэлбэрээр татан авах боломжтой. Мөн тус системээр олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдээс ил тод байдлын тайланг хүлээн авдаг бөгөөд тайлангаар тухайн аж ахуйн нэгжээс улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн бүх төрлийн татвар, төлбөр,			

	хураамж, хандив дэмжлэгээс гадна тухайн жилд олборлосон борлуулсан бүтээгдэхүүн, нөхөн сэргээсэн талбайн мэдээллийг хүлээн авч олон нийтэд ил тод болгон мэдээлж байна.
Дуусах өдөр	2016
Дараагийн алхмууд	-
Нэмэлт мэдээлэл (уг үүрэг амлалтыг гүйцэлтдүүлэхэд ямар ажил үлдсэн талаар болон түүнийг хэрэгжүүлэхэд тулгарч буй ямар нэгэн бэрхшээл, эрсдэл байгаа эсэхийг тодорхойлох)	
АМГТГ-ын кадастрын системд газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн мэдээллүүдийг оруулах шаардлагатай.	

Үйл ажиллагааны гүйцэтгэлийн загвар хүснэгт		
3.3.1.5. Ашигт малтмал, газрын тос, газар, ус ашиглах гэрээний ил тод байдал		
Хариуцан хэрэгжүүлэгч байгууллага	Уул, уурхай, хүнд үйлдвэрийн яам, Олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах төслийн ажлын алба,	
Хэрэгжүүлэгч байгууллагаас хариуцсан хүний нэр	Н.Чинбаатар, Ш.Цолмон	
Газар, хэлтсийн нэр	Кадастрын хэлтсийн дарга, Ажлын албаны зохицуулагч	
Имейл хаяг	Chinbaa_8763@yahoo.com	
Утас	263640	
Бусад оролцогч талууд	Засгийн газар	-
	ИНБ-ууд, хувийн салбар, ажлын хэсгүүд, болон олон талт оролцоо	Нээлттэй нийгэм форум ТББ
Гол зорилт	Нээлттэй гэрээний түншлэлд нэгдэж, гэрээний ил тод байдлыг хангах	
Үйл ажиллагааны товч тодорхойлолт (140 тэмтэгтийн хязгаартай)	Ашигт малтмал, газрын тос, газар, ус зэрэг нийтийн өмчийг ашиглахаар байгуулж байгаа гэрээний ил тод байдлыг хангах	
Хамаарал: Уг үйл ажиллагаа нь НЗТ-ийн зарчмууд болох мэдээллийн нээлттэй байдал, төрийн хариуцлага, иргэний оролцоо, технологийг дэвшил зэргийг хэрхэн хангаж буй талаар товчхон тодорхойлох.	НЗТ-ийн ил тод, нээлттэй байдлын зарчмыг дэмжиж буй байдлаараа хамааралтай.	

Уг үйл ажиллагааны зорилтод үр дүн: Засгийн газрыг хэрхэн илүү нээлттэй болгож, Засгийн газрын үйл ажиллагааг сайжруулж буй талаар товчхон тодорхойлох.	Ашигт малтмал, газрын тос, газар, ус зэрэг нийтийн өмчийг ашиглахаар байгуулсан гэрээг нийтэд ил тод болгож байгаагаараа дамжуулан Засгийн газрыг илүү нээлттэй болгож байна.			
Гүйцэтгэлийн түвшин	Эхлээгүй	Хязгаарлагдмал	Биелэгдэх дөхөж байгаа	Биелэгдсэн
				х
Үр дүнгийн тодорхойлолт: Тайлангийн хугацаан дахь онцлох үйл ажиллагаануудын үр дүн	Гэрээний ил тод байдлыг хангах хүрээнд ОУИТБС-ын Үндэсний зөвлөлөөс оролцогч гурван талын төлөөлөл бүхий ажлын дэд хэсгийг Уул уурхайн ямаар ахлуулан байгуулж ажилласан. Тус ажлын дэд хэсэг нь гэрээг ил болгохтой холбоотой эрх зүйн орчинг судалж, гэрээ байгуулсан талуудтай уулзалт зохион байгуулж, гэрээний хуулбарыг татан авч сан бүрдүүлсэн. Улмаар эрдэс баялгийн салбарт байгуулсан гэрээний ил тод байдлын цахим санг бүрдүүлэхээр ажиллаж байна. Тус сан нь www.iltodgeree.mn хаягт байрлан ажиллах бөгөөд эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд Засгийн газар болон төрийн холбогдох байгууллагатай байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээ, Бүтээгдэхүүн хуваах гэрээ, Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ, Газар, ус ашиглах гэрээ гэх зэрэг гэрээнүүдийг ил тод болгон олон нийтэд мэдээлнэ. Мэдээллийн санд орсон гэрээнүүд нь метадата, гэрээний PDF хувилбар, PDF хувилбараас хөрвүүлсэн текст хувилбар, холбогдох заалтуудад тайлбар хийсэн аннотациас бүрдэнэ. Хэрэглэгчид дээрхи мэдээллүүдээс хайлт хийх, харьцуулах боломжтой байхаас гадна мэдээллүүдийг татаж авах боломжтой. Уул уурхайн салбарын хүрээнд Ашигт малтмалын тухай хуулийн дагуу Тогтвортой байдлын гэрээ, Хөрөнгө оруулалтын гэрээ, Орд ашиглах гэрээ байгуулж ажилласан. Тогтвортой байдлын гэрээг Бороогоулд ХХК-тай Бороогийн алтны ордыг ашиглахад, Цайрт минерал ХХК-тай Төмөртийн Овооны цайрын ордыг ашиглахад, Нарийн сухайтын нүүрсний ордыг ашиглахад Чинхуа-МАК-Нарийнсухайт ХХК-тай тус тус байгуулсан. Хөрөнгө оруулалтын гэрээг ганц Оюу толгой ХХК-тай Оюу толгойн ордыг ашиглахад байгуулсан. Тогтвортой байдлын болон Хөрөнгө оруулалтын гэрээнүүд бүгд олон нийтэд ил тод болсон. Ашигт малтмалын тухай			

хуулийн 11 дүгээр зүйл. “Төрийн захиргааны байгууллага нь ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл шинээр олгох, дахин олгох, цуцлах, шилжүүлэх, барьцаалах, талбайг хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан өгөх, шилжүүлэх ажиллагааг олон нийтийн хяналтын дор явуулах,” “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллах” заалтыг хуулинд нэмэлт өөрчлөлтөөр оруулж уг гэрээний загварыг Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолоор батлуулсан.

ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн дэргэдэх гэрээний ил тод байдлын ажлын дэд хэсгээс орон нутагтай байгуулсан гэрээний хуулбарыг татан авч, сан бүрдүүлсэн. Одоогийн байдлаар 15 аймаг, нийслэл хариу ирүүлж 59 гэрээний мэдээлэл, үүнээс 25 гэрээний хуулбарыг ирүүлсэн. Архангай, Дархан-уул, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл аймгууд хариу ирүүлээгүй болно.

“Газрын тосны тухай” хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаар газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд Бүтээгдэхүүн хуваах гэрээний зарчмыг баримтлан ажиллаж байна. Бүтээгдэхүүн хуваах гэрээний загварыг Засгийн газрын 2015 оны 104 дүгээр тогтоолоор батлуулсан. ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн дэргэд байгуулагдсан гэрээний ил тод байдлыг хангах ажлын дэд хэсгийн зүгээс Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдтэй уулзалт зохион байгуулж, гэрээг ил тод болгох асуудлаар зөвшилцөж, гэрээг ил болгохдоо геологи, хайгуултай холбоотой хэсэг буюу Хавсралт Б-гээс бусад хэсгийг ил болгох боломжтой гэсэн нэгдсэн ойлголтонд хүрсэн. Гэрээний загвар www.legalinfo.mn цахим хуудсанд нийтэд нээлттэй тавигдсан.

Мөн Бүтээгдэхүүн хуваах гэрээт компанийн жагсаалтыг яам, АМГТГ-ын цахим хуудсанд байршуулж олон нийт танилцах нөхцлийг бүрдүүлсэн. Мөн байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгасан гэрээний загварыг Засгийн газрын 2015 оны 430 дунгаар тогтоолоор баталсан. Өнөөдрийн байдлаар нийт 25 Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан. Эдгээр гэрээт талбайд хамрагдсан аймаг болгонд АМГТГ-аас жил

	бүр орон нутгийн уулзалтыг зохион байгуулж орон нутагт мэдээлэл сурталчилгааг тогтмол хийж ажиллаж байна. Газрын тосны салбарт хөрөнгө оруулалт хийхтэй холбогдсон аливаа шийдвэр гаргах үйл ажиллагаанд тодорхой хугацааг байгууллага тус бүрээр нь тогтоож өгснөөр Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгын давуу тал болж өгсөн. Мөн Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах шат дамжлагыг багасгасан давуу талтай.
Дуусах өдөр	2015
Дараагийн алхмууд	-
Нэмэлт мэдээлэл (уг үүрэг амлалтыг гүйцэлтдүүлэхэд ямар ажил үлдсэн талаар болон түүнийг хэрэгжүүлэхэд тулгарч буй ямар нэгэн бэрхшээл, эрсдэл байгаа эсэхийг тодорхойлох)	
-	

Үйл ажиллагааны гүйцэтгэлийн загвар хүснэгт		
3.3.1.6. Байгаль орчны талаарх мэдээллийн ил тод байдал		
Хариуцан хэрэгжүүлэгч байгууллага	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам	
Хэрэгжүүлэгч байгууллагаас хариуцсан хүний нэр	А.Сайнбаяр	
Газар, хэлтсийн нэр	Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн	
Имейл		
Утас		
Бусад оролцогч талууд	ЗГХЭГ	ЗГХЭГ
	Монголын байгаль орчны иргэний зөвлөл болон бусад иргэний нийгмийн байгууллагууд	Монголын байгаль орчны иргэний зөвлөл болон бусад иргэний нийгмийн байгууллагууд
Гол зорилт		Байгаль орчны ил тод байх ёстой мэдээллийн жагсаалт гаргаж, ил тод болгох
Үйл ажиллагааны товч тодорхойлолт (140 тэмтэгтийн хязгаартай)		Байгаль орчны ил тод байх ёстой мэдээллийн жагсаалт гаргаж, байгаль орчин, хүний эрүүл мэндэд хор хохирол учруулахуйц үйл ажиллагааны талаарх мэдээллийг ил тод болгох үүргийг хувийн хэвшлийн байгууллагад давхар оногдуулж, мэдээллийг ил тод, хүртээмжтэй болгох механизмыг тодорхойлж, хэрэгжүүлэх.

Хамаарал: Уг үйл ажиллагаа нь НЗТ-ийн зарчмууд болох мэдээллийн нээлттэй байдал, төрийн хариуцлага, иргэний оролцоо, технологийг дэвшил зэргийг хэрхэн хангаж буй талаар товчхон тодорхойлох.	НЗТ-ийн ил тод, нээлттэй байдлын зарчмыг дэмжиж буй байдлаараа хамааралтай.			
Уг үйл ажиллагааны зорилтод үр дүн: Засгийн газрыг хэрхэн илүү нээлттэй болгож, Засгийн газрын үйл ажиллагааг сайжруулж буй талаар товчхон тодорхойлох.	Байгаль орчин болон хүний эрүүл мэндэд хор хохирол учруулахуйц үйл ажиллагааны талаарх мэдээллийг ил тодоор мэдээлэх үүргийг төр болон хувийн хэвшилд оногдуулснаар Засгийн газрын үйл ажиллагааг илүү ил тод, хариуцлагатай болгож байна.			
Гүйцэтгэлийн түвшин	Эхлээгүй	Хязгаарлагдмал	Биелэгдэх дөхөж байгаа	Биелэгдсэн
				х
Үр дүнгийн тодорхойлолт: Тайлангийн хугацаан дахь онцлох үйл ажиллагаануудын үр дүн	БОАЖЯ нь Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн Байгаль орчны мэдээллийн төвөөр дамжуулан “Байгаль орчны мэдээллийн сан”-г үүсгэн eic.mn хаягаар нээлттэй 22 дэд сангаар байгаль орчны өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх, цуглуулах, дамжуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, баяжуулах, өөрчлөх, шинэчлэх, хамгаалах зэрэг үйл ажиллагааг хангах мэдээллийн технологийн системийг бий болгосон.			
	Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр www.agaar.mn цахим сайт болон LED дэлгэц, Мобайл программыг ашиглан Android ба Apple-ийн үйлдлийн системд зориулсан аппликейшн нэвтрүүлснээр агаарын чанарын хяналтын мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэх тогтолцоог бүрдүүлсэн. Цаг уур орчны шинжилгээний газраас www.tsag-agaar.mn сайтаар мэдээллийг бүрэн мэдээлж хэвшсэн. Байгаль орчны салбарын мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор www.mne.mn , www.eic.mn хаягаар Байгаль орчны мэдээллийн санг ажиллуулан нээлттэй мэдээллийг шуурхай, бодитой хүргэж хэвшсэн болно.			
Дуусах өдөр	2016			
Дараагийн алхмууд	-			
Нэмэлт мэдээлэл (уг үүрэг амлалтыг гүйцэлтдүүлэхэд ямар ажил үлдсэн талаар болон түүнийг хэрэгжүүлэхэд тулгарч буй ямар нэгэн бэрхшээл, эрсдэл байгаа эсэхийг тодорхойлох)				

Үйл ажиллагааны гүйцэтгэлийн загвар хүснэгт				
3.3.1.7. Гадаадын хөрөнгө оруулалттай төсөл, хөтөлбөрийн талаарх мэдээллийг ил тод болгох				
Хариуцан хэрэгжүүлэгч байгууллага		Сангийн яам		
Хэрэгжүүлэгч байгууллагаас хариуцсан хүний нэр		Б.Мөнх-Эрдэнэ		
Газар, хэлтсийн нэр		Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн		
Имэйл хаяг				
Утас				
Бусад	Яамд	Бусад		
	CSOs, private sector, working groups, Multilaterals	-		
Гол зорилт		Байгаль орчны ил тод байх ёстой мэдээллийн жагсаалт гаргаж, ил тод болгох		
Үйл ажиллагааны товч тодорхойлолт (140 тэмтэгийн хязгаартай)		Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн, хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн жагсаалт, тэдгээрийн гэрээний мөнгөн дүн, зээлийн буцаан төлөлт болон хүүтэй холбоотой үндсэн нөхцлийн мэдээлэл, төсөл хэрэгжүүлэгч байгууллага, төслийн удирдах хорооны бүрэлдэхүүн, хэрэгжүүлэх нэгжийн талаарх мэдээллийг ил болгох		
Хамаарал: Уг үйл ажиллагаа нь НЗТ-ийн зарчмууд болох мэдээллийн нээлттэй байдал, төрийн хариуцлага, иргэний оролцоо, технологийг дэвшил зэргийг хэрхэн хангаж буй талаар товчхон тодорхойлох.		НЗТ-ийн ил тод, нээлттэй байдлын зарчмыг дэмжиж буй байдлаараа хамааралтай.		
Уг үйл ажиллагааны зорилтод үр дүн: Засгийн газрыг хэрхэн илүү нээлттэй болгож, Засгийн газрын үйл ажиллагааг сайжруулж буй талаар товчхон тодорхойлох.		Гадаадын хөрөнгө оруулалттай хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн талаарх мэдээллийг ил тод болгосоноор хэдийн хэмжээний зээл, хэдий хэмжээний буцалтгүй тусламж орж ирсэн болон тэдгээрийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг ил тод болгосоноороо Засгийн газрыг илүү нээлттэй, ил тод болгож байна.		
Гүйцэтгэлийн түвшин	Эхлээгүй	Хязгаарлагд мал	Биелэгдэх дөхөж байгаа	Биелэгдсэн
				х

Үр дүнгийн тодорхойлолт: Тайлангийн хугацаан дахь онцлох үйл ажиллагаануудын үр дүн	Үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээний удирдлагын мэдээллийн нэгдсэн санг интернетэд суурилан хийж тогтмол ажиллагаанд оруулаад байна. /www.odamis.mof.gov.mn/ Уг мэдээллийн сангаас олон нийтийн эрхээр хандаж болох бөгөөд дараах мэдээллийг авах, ашиглах боломжтой. Үүнд: 1. Гадаадын зээл, туслажийн хөрөнгөөр хэрэгжсэн, хэрэгжиж байгаа, хөтөлбөрийн жагсаалт, гүйцэтгэгч байгууллага, бүрэлдэхүүн хэсэг 2. Тэдгээрийн мөнгөн дүн, зээлийн хүүтэй холбоотой үндсэн нөхцлийн мэдээлэл 3. Төсөл хөтөлбөрийн санхүүжилт, гүйцэтгэл, зарлагын мэдээлэл 4. Төсөл хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, үнэлгээ, хяналт шинжилгээ, тэдгээртэй холбоотой мэдээлэл 5. Төсөл хөтөлбөр хэрэгжиж эхлэх үеийн гэрээ, санамж бичиг, сар, улирал, жилийн тайлангууд, хаалтын тайлангууд зэрэг баримт бичгүүдийг хавсаргасан болно. Олон улсын байгууллагаас авсан зээл, тусламж, төсөл хөтөлбөрүүдийн талаарх мэдээллийг ил тод болгох үүднээс хэрэгжиж дууссан болон хэрэгжиж байгаа 1139 төслийн мэдээллийг өөрсдийн мэдээллийн сан дээр тулгуурлан системд оруулаад байна.
Дуусах өдөр	2016
Дараагийн алхмууд	-
Нэмэлт мэдээлэл (уг үүрэг амлалтыг гүйцэлтдүүлэхэд ямар ажил үлдсэн талаар болон түүнийг хэрэгжүүлэхэд тулгарч буй ямар нэгэн бэрхшээл, эрсдэл байгаа эсэхийг тодорхойлох)	
-	

Үйл ажиллагааны гүйцэтгэлийн загвар хүснэгт	
3.3.1.8. Төсвийн хөрөнгө оруулалттай 80 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авах ажиллагааны гэрээг ил тод болгох	
Хариуцан хэрэгжүүлэгч байгууллага	Сангийн яам
Хэрэгжүүлэгч байгууллагаас хариуцсан хүний нэр	Б.Сугармаа
Газар, хэлтсийн нэр	Хууль, худалдан авах ажиллагаа бодлогын газрын мэргэжилтэн
Ииейл хаяг	
Утас	

Бусад оролцогч талууд	Засгийн газар	Худалдан авах ажиллагааны газар			
	ИНБ-ууд, хувийн салбар, ажлын хэсгүүд, болон олон талт оролцоо	-			
Гол зорилт		Төрийн ил тод байдлыг нэмэгдүүлэх			
Үйл ажиллагааны товч тодорхойлолт (140 тэмтэгтийн хязгаартай)		Төсвийн хөрөнгө оруулалттай 80 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авах ажиллагааны гэрээг ил тод болгох.			
Хамаарал: Уг үйл ажиллагаа нь НЗТ-ийн зарчмууд болох мэдээллийн нээлттэй байдал, төрийн хариуцлага, иргэний оролцоо, технологийг дэвшил зэргийг хэрхэн хангаж буй талаар товчхон тодорхойлох.		НЗТ-ийн ил тод, нээлттэй байдлын зарчмыг дэмжиж буй байдлаараа хамааралтай.			
Уг үйл ажиллагааны зорилтод үр дүн: Засгийн газрыг хэрхэн илүү нээлттэй болгож, Засгийн газрын үйл ажиллагааг сайжруулж буй талаар товчхон тодорхойлох.		Улсын төсвийн зарцуулалтын талаарх мэдээллийг олон нийтэд мэдээллэн Засгийн газрын ил тод байдлыг хангах.			
Гүйцэтгэлийн түвшин		Эхлээгүй	Хязгаарлагдмал	Биелэгдэх дөхөж байгаа	Биелэгдсэн
					х
Үр дүнгийн тодорхойлолт: Тайлангийн хугацаан дахь онцлох үйл ажиллагаануудын үр дүн		Томоохон хэмжээний тендерийн зар, үр дүнг нэгтгэн мэдээллэж байх, энэ чиглэлийн мэдээллийн бааз бий болгох, мөн худалдан авах ажиллагаатай холбоотой хууль, журам, заавар, жишиг бичиг баримтаар олон нийтийг хангах, тендер шалгаруулалттай холбоотой асуудлаар онлайн хэлэлцүүлэг зохион байгуулах, сонирхсон этгээдүүдэд мэргэжлийн заавар, зөвлөгөө өгөх зорилго бүхий https://e-tender.mn болон https://www.tender.gov.mn цахим хуудсыг ажиллуулж байна. Нэгдсэн цахим хуудасны системийг боловсронгуй болгож нийт 10009 тендерийн урилгыг байршуулсан байна. Энэхүү цахим хуудсандаа 2016 оны байдлаар 2965 тендерийн урилга нийтлэгдсэн боловч 567 үр дүн нийтлэгдэж хангалтгүй ажилласан байгаа тул анхааран ажиллаж захиалагч талаас тендерийн үр дүнг мэдээлж байх шаардлага тавин ажиллаж байна.			
Дуусах өдөр		2016			

Дараагийн алхмууд	-
Нэмэлт мэдээлэл (уг үүрэг амлалтыг гүйцэлтдүүлэхэд ямар ажил үлдсэн талаар болон түүнийг хэрэгжүүлэхэд тулгарч буй ямар нэгэн бэрхшээл, эрсдэл байгаа эсэхийг тодорхойлох)	
-	

Үйл ажиллагааны гүйцэтгэлийн загвар хүснэгт				
3.3.2.1. Төрийн үйлчилгээг сайжруулахад иргэдийн оролцоог хангах				
Хариуцан хэрэгжүүлэгч байгууллага		Хууль зүйн яам		
Хэрэгжүүлэгч байгууллагаас хариуцсан хүний нэр		Энхжаргал		
Газар, хэлтсийн нэр		Төрийн захиргаа, удирдлагын газрын мэргэжилтэн		
Имэйл				
Утас				
Бусад оролцогч талууд	Засгийн Газар	ЗГХЭГ		
	ИНБ-ууд, хувийн салбар, ажлын хэсгүүд, болон олон талт оролцоо	-		
Гол зорилт		Төрийн үйлчилгээг сайжруулах, иргэдийн оролцоог хангах		
Үйл ажиллагааны товч тодорхойлолт (140 тэмтэгтийн хязгаартай)		Төв болон орон нутгийн түвшинд төрийн үйлчилгээг төлөвлөх, боловсруулахад иргэдийн оролцоог хангах		
Хамаарал: Уг үйл ажиллагаа нь НЗТ-ийн зарчмууд болох мэдээллийн нээлттэй байдал, төрийн хариуцлага, иргэний оролцоо, технологийг дэвшил зэргийг хэрхэн хангаж буй талаар товчхон тодорхойлох.		НЗТ-ийн ил тод, нээлттэй, иргэдийн оролцоог хангаж байгаагаараа хамааралтай.		
Уг үйл ажиллагааны зорилтод үр дүн: Засгийн газрыг хэрхэн илүү нээлттэй болгож, Засгийн газрын үйл ажиллагааг сайжруулж буй талаар товчхон тодорхойлох.		НЗТ-ийн иргэдийн оролцоог хангах зарчмыг хангаж буй байдлаараа Засгийн газрын үйл ажиллагааг иргэдэд ил тод, нээлттэй болгож, иргэдийн саналыг тусган төрийн үйлчилгээг сайжруулж байна.		
Гүйцэтгэлийн түвшин	Эхлээгүй	Хязгаарлагдмал	Биелэгдэх дөхөж байгаа	Биелэгдсэн
			х	

Үр дүнгийн тодорхойлолт: Тайлангийн хугацаан дахь онцлох үйл ажиллагаануудын үр дүн	Төрийн бодлого, шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангахад чиглэгдсэн “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль” 2015 оны 11 дүгээр сард, “Нийтийн сонсголын тухай хууль” 2015 оны 7 дугаар сард, “Захиргааны Ерөнхий Хууль” 2015 оны 6 дугаар сард, “Хууль тогтоомжийн тухай хууль” 2015 оны 5 дугаар сард тус тус Улсын Их Хурлаар хэлэлцэгдэн батлагдсан. Уг хуулиуд баталснаар төрийн бодлого, шийдвэр хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актыг батлахаас өмнө төрийн байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн шинжээчдийн саналыг авч тусгадаг болсон нь төрийн байгууллагын шийдвэр ил тод, олон нийтийн саналыг тусгасан байх нөхцлийг бүрдүүлж байгаа юм. Мөн “Төсвийн тухай хууль”-д тусгах орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төслийг олон нийтэд нээлттэй хэлэлцүүлж баталж хэвшсэн. Иргэдийн оролцооны эрхийг иргэд олон нийтэд сурталчилан таниулах, иргэд эрх, үүргээ бодитойгоор хэрэгжүүлж төрийн үйлчилгээг сайжруулах хүрээнд “Хууль тогтоомж сурталчлах нэгдсэн арга хэмжээ”-г 2016 онд нийслэлийн төвийн 6 дүүрэгт, болон Багахангай, Багануур, Налайх дүүргүүдэд зохион байгуулсан. Уг арга хэмжээний үеэр 11 агентлаг, байгууллагын нийт 51279 ширхэг гарын авлага, танилцуулга зэрэг сурталчилгааны материалыг иргэдэд түгээн сурталчилж, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд батлагдсан хуулиудын талаар танилцуулсан.
Дуусах өдөр	2016
Дараагийн алхмууд	-
Нэмэлт мэдээлэл (уг үүрэг амлалтыг гүйцэлтдүүлэхэд ямар ажил үлдсэн талаар болон түүнийг хэрэгжүүлэхэд тулгарч буй ямар нэгэн бэрхшээл, эрсдэл байгаа эсэхийг тодорхойлох)	
-	

Үйл ажиллагааны гүйцэтгэлийн загвар хүснэгт	
3.3.2.2. Төрийн үйлчилгээг цахимжуулах	
Хариуцан хэрэгжүүлэгч байгууллага	Мэдээлэл технологи, шуудан, харилцаа холбооны газар

Хэрэгжүүлэгч баагууллагаас хариуцсан хүний нэр				
Газар, хэлтсийн нэр		Мэдээллийн технологийн хэлтсийн мэргэжилтэн		
Имейл хаяг				
Утас				
Бусад оролцогч талууд	Засгийн газар	ЗГХЭГ		
	ИНБ-ууд, хувийн салбар, ажлын хэсгүүд, болон олон талт оролцоо	-		
Гол зорилт		Үйлчилгээг цахимжуулах, шуурхай хүргэх шинэлэг аргуудыг нэвтрүүлэх		
Үйл ажиллагааны товч тодорхойлолт (140 тэмтэгтийн хязгаартай)		Иргэд газар нутгийн байршил, оршин суугаа газраас үл хамааран цахим үйлчилгээ авах боломж бүхий дэд бүтцийг хөгжүүлэх. Төрийн үйлчилгээний порталыг ажиллуулж 20-30 төрлийн үйлчилгээг цахимжуулах		
Хамаарал: Уг үйл ажиллагаа нь НЗТ-ийн зарчмууд болох мэдээллийн нээлттэй байдал, төрийн хариуцлага, иргэний оролцоо, технологийг дэвшил зэргийг хэрхэн хангаж буй талаар товчхон тодорхойлох.		Засгийн газраас иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээнд технологийн давуу талыг ашиглаж байгаагаараа НЗТ-ийн технологи, инновацийн үнэ цэнийг нэмэгдүүлж буй байдлаараа хамааралтай.		
Уг үйл ажиллагааны зорилтод үр дүн: Засгийн газрыг хэрхэн илүү нээлттэй болгож, Засгийн газрын үйл ажиллагааг сайжруулж буй талаар товчхон тодорхойлох.		НЗТ-ийн технологи, инновацийн дэвшлийг ашиглах зарчмын дагуу төрийн үйлчилгээг шуурхай үзүүлж, сайжруулахад цахимжуулах шинэлэг аргыг нэвтрүүлж буй байдлаараа Засгийн газрын үйл ажиллагаанд сайнаар нөлөөлж байна.		
Гүйцэтгэлийн түвшин		Эхлээгүй	Хязгаарлагдмал	Биелэгдэх дөхөж байгаа
				х
